

2024 он 05 сар 06 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, Ноолуурын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих ногоон зээлийн гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

- Говь ХК нь Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтран ХААН Банктай байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - Зээлийн эрхийн хэмжээг 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгөөр нэмэгдүүлэн 115,000,000,000 (нэг зуун арван таван тэрбум) төгрөг болгосугай.
 - Зээлийн эрхийн хугацааг 36 сараар буюу 2029 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сунгахыг зөвшөөрсүгэй.
 - Таван Богд Проперти ХХК нь Таван Богд Холдингс ХХК-тай бизнес нэгдэл хийсэнтэй холбоотой Таван Богд Проперти ХХК-г хамтран үүрэг гүйцэтгэгчээс хасахыг зөвшөөрсүгэй.
- Дээрх зээлийн эрх нээх гэрээний хүрээнд Говь ХК нь ХААН Банктай дараах нөхцөлийн дагуу “Ноолуурын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих ногоон зээл”-ийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - Зээлийн хэмжээ: 30,000,000,000 (гучин тэрбум) төгрөг;
 - Зээлийн хугацаа: 24 (хорин дөрвөн) сар;
 - Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа: 6 (зургаан) сар;
 - Төгрөгийн зээлийн хүү жилийн: 16.0 (арван зургаан) хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн хувьсах 10.0 (арван) хувь.
- Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
- Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, хөнгөлөлттэй зээлийн гэрээ болон холбогдох бусад гэрээ, бичиг баримтад Говь ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил)-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР